



**Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 7 сарын 01-ний А-194 тоот тушаалаар хүчингүй болсон**

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ  
БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАХ ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

2009 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 139 "Байгаль орчныг хамгаалах тухай" Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг үндэслэн ТУШААХ нь: 1.2009 онд судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглах байгалийн нэн ховор ургамлын дээд хэмжээг 1 дүгээр хавсралтаар, Эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх байгалийн ховор ургамлын дээд хэмжээг 2 дугаар хавсралтаар, Эмийн болон хүнсний үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх байгалийн элбэг ургамлын дээд хэмжээг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай. 2.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.ЭНХБАТ/-Т даалгасугай. САЙД Л.ГАНСҮХ Улсын бүртгэлд  
2009 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 3063 дугаарт бүртгэгдсэн